

# ВАКЦИН ХИЙЛГЭСЭН ХҮМҮҮСИЙН АНХААРАЛД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ



Вакцинжуулалт нь цар тахлын эх үүсвэр, тархалтыг хумих хамгийн үр дүнтэй аргуудын нэг юм. Вакцинжуулалтад олон хүнийг хамруулсны ачаар маш олон халдварт өвчний (жишээ нь: салхин цэцэг, халдварт саа) тархалтыг эрс хумиж улмаар бүрэн устгаж чадсан түүх олон бий. Энэ нь КОВИД-19-ийн тохиолдолд ч мөн бүрэн боломжтой юм. Хүн амын вакцинд хамрагдсан хувь хэмжээ өндөр байх тусам халдвар авах, тараах хүмүүсийн тоо бага байдаг аж.

## Вакцинжуулах цэгт баримтлах дүрэм

- ▶ Тухайн цэгт ажиллаж буй эмнэлгийн байгууллагын болон бусад ажилтны өгсөн зааварчилгааг дагаж мөрдөх
- ▶ Вакцинжуулах цэгт байх хугацаандаа **ам, хамраа халхлах** (амны хаалт зүүх, амьсгалын аппарат ашиглах).
- ▶ Боломжтой тохиолдол бүрд **гараа ариутгах**
- ▶ Тухайн цэгт ажиллаж буй эмнэлгийн байгууллагын болон бусад ажилтан Таны эрүүл мэндийн байдлын талаар асуулга авахад **үнэн зөв хариулах**.

## Вакцин хийх тухай

- ▶ Танд вакцин хийхээс өмнө эрүүл мэндийн ажилтан Таныг эмчийн үзлэгт хамруулж, Таны эрүүл мэндийн талаар болон ямар нэг харшилтай эсэх талаар хэд хэдэн асуулт асууна.
- ▶ Вакциныг **мөрний булчинд тарина**.
- ▶ Вакцин хийлгэсний дараа дотор муухайрч болох учир шууд гарч явалгүй **хүлээлгийн өрөөнд 15 минут сууж харзнах ёстой**.
- ▶ Вакцин хийлгэсний дараа дотор муухайрч бие тань тавгүйтвэл, тухайн цэгт ажиллаж байгаа **эрүүл мэндийн ажилтанд даруй мэдэгдэх хэрэгтэй**.
- ▶ Уг вакцин нь хоёр тунтай бөгөөд эхний тунг хийлгэсэн тохиолдолд COVID-19 өвчний эсрэг маш сайн дархлаатай болохын тулд уг вакцины хоёрдахь тунг заавал хийлгэх хэрэгтэй.

## Вакцин хийлгэсний дараа яах вэ?

- ▶ Вакцин хийлгэсний маргааш буюу дараагийн өдөр нь **ачаалал авч ядралгүй амрах хэрэгтэй**.
- ▶ Хоёр тунт вакцины эхний тунг хийлгэсний дараа COVID-19 өвчний эсрэг дархлаа сул байх тул эхний тунг хийлгэсэн ч Та халдвар авч болзошгүй, иймээс **халдвар авахаас урьдчилан сэргийлэх** (амны хаалт зүүх, хүн хоорондын зай барих, гараа тогтмол угаах, ариутгах гэх мэт) **бүхий л арга хэмжээг авч өөрийгөө болон бусдыг хамгаалах хэрэгтэй**.
- ▶ Хоёр тунт вакцины хоёрдахь тунг тариулах өдөр товлосон цагтаа очиж вакцинаа хийлгэх нэн чухал шаардлагатай.

## Вакцин хийлгэсний дараа ямар гаж нөлөө гардаг вэ?

- ▶ Вакцин хийлгэсний дараа тариулсан газар хөндүүрлэж хавдах, ядрах, толгой өвдөх, булчин, үе мөч өвдөх, хаяа бага зэрэг халуурах, даарах зэрэг реакци буюу шинж тэмдгүүд илэрч болох бөгөөд эдгээр нь хэдэн хоногийн дараа ямар нэг эмчилгээ хийлгэлгүй **арилж зүгээр болно**.
- ▶ Вакцин хийлгэсний дараа илрэх дээрх реакциуд нэлээд түгээмэл бөгөөд өөр бусад төрлийн вакцин хийлгэсний дараа ч мөн илэрдэг аж. Вакцин хийлгэсний дараа ноцтой шинж тэмдэг үзүүлж реакци өгөх нь маш ховор байдаг.
- ▶ Вакцин хийлгэсний дараа илрэх дээрх реакциуд нь тааламжгүй байж болох ч **КОВИД-19 өвчин** Таныг хүндээр өвчлүүлж, таны эрүүл мэндэд удаан хугацааны сөрөг үр дагавар учруулж **эрүүл мэндийг тань ноцтой хохироож болзошгүй**.
- ▶ Хэрэв эдгээр шинж тэмдэг гурваас дээш хоногт үргэлжилвэл, хүндэрвэл эсвэл өөр бусад шинж тэмдэг илэрвэл, **өрхийн эмчдээ хандаж** биеийн байдлынхаа талаар мэдэгдэх хэрэгтэй.

**Хүн амыг вакцинжуулах нь Ковид-19-ийн цар тархалтыг зогсоох хамгийн үр дүнтэй арга гэдэг нь нэгэнт батлагдсан бөгөөд хүн амыг цаг алдалгүй вакцинжуулснаар цар тахлын өмнөх хэвийн амьдралд эргэн орох боломжтой.**

**КОВИД-19-ийн эсрэг вакцин хийлгэснээр Та өөрийгөө төдийгүй гэр бүлээ, эргэн тойрныхоо хүмүүсийг мөн адил халдвараас хамгаалах юм.**